ХУДАЛДАН АВАЛТ, ГЭРЭЭЛЭЛТИЙН ГАЗРЫН ХУУЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ДОРЖИЙН УЯНГЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилго 1. Даатгалын эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ. | | | | | | | |
| Зорилт 1.3. Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. | | | | | | | |
| 1 | БСТ-2.1.3<br>Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хэсэгт санал хүргүүлнэ. | Хүргүүлсэн саналын тоо | ЭМДҮЗ-ийн 3 тогтоол, 1 тушаалд санал өгч боловсруулагдан батлагдсан. | Холбогдох хуулийн төслүүдэд санал боловсруулж, ажлын хэсэгт санал хүргүүлсэн байна. | “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, цуглуулах, төвлөрүүлэх журам”-ын төсөлд санал хүргүүлсэн. | I - II улирал | 100% |
| 2 | Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хууль, эрх зүйн орчинд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөрчил, хийдэл, давхардлыг арилгах санал боловсруулах ажлын хэсэгт ажиллах. | Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөрчил, хийдэл, давхардлыг илэрүүлсэн байна. | ЭМДЕГ-ын даргын 2025 оны А/08 дугаар тушаал хэрэгжсэн. | Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг танилцуулсан байна. | Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хууль, эрх зүйн орчинд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөрчил, хийдэл, давхардлыг арилгах санал боловсруулж, тайлан гаргасан. | I - II улирал | 100% |
| 3 | *ЭМДТХ-10.1, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.12*<br><br>“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх нийтлэг | Шинэчлэн батлагдсан журам | ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/61, 2023 оны А/01 дүгээр тушаал хэрэгжсэн. | “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх нийтлэг журам”-ыг | Тухайн ажлыг эхлэх хугацаа болоогүй байгаа бөгөөд төсөл боловсруулагдаж эхлэх шатандаа явж байна. | III-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | журам"-ыг шинэчлэн баталж, мөрдүүлнэ. | | | шинэчлэн батлагдсан байна. | | | |
| 4 | "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг шинэчлэн батлуулж, мөрдөнө. | Шинэчлэн батлагдсан тогтоол | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 13 дугаар тогтоол хэрэгжсэн. | | ЭМДҮЗ-ийн "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай" тогтоолыг шинэчлэн батлуулахаар ажиллаж байгаад бөгөөд тогтоол болон гэрээний төсөлд холбогдох байгууллагуудаас санал аван ажиллаж байна. | I-III улирал | 60% |
| Зорилт 1.4. Хөндлөнгийн хяналтад тулгуурласан хамтын ажиллагааг бэхжүүлнэ. | | | | | | | |
| 1 | Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, холбогдох байгууллагатай хамтран ажиллана. | Шийдвэрлэсэн гомдол мэдээллийн тоо | Шийдвэрлэсэн гомдол мэдээллийн тоо | Шийдвэрлэсэн гомдол мэдээллийн тоо | Зөрчлийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн хэрэгжүүлэх чиг үүрэг, эрхийн талаар холбогдох дүгнэлт гаргасан. | I - II улирал | 100% |
| 2 | Хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах гэрээний төслийг бэлтгэн гэрээ хийх. МТХ-т цахим системд нэвтрэх эрхийн асуудлыг шийдвэрлэх, мэдээний сан үүсгэх, тайлагнах. | Гэрээ байгуулахад шаардлагатай баримтыг үндэслэн байгуулсан байх. | - | Ирүүлсэн хүсэлтийн дагуу судлан тухай бүх гэрээ байгуулах эсэхийг шийдвэрлэх. | Хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах гэрээ 2025 оны мэдээллийн санг үүсгэж Эрүүл мэндийн байгууллагын ажилтан 36, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын албан хаагч 4 нийт 40 гэрээ байгуулсан байна. | I - II улирал | 100% |
| Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна | | | | | | | |
| Зорилт 3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийг чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч чанарын хяналтыг сайжруулна. | | | | | | | |
| 1 | ГГТ- 3.1.1 Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох эрүүл | Шинэчлэн байгуулсан, гэрээний тоо | - | 2024 оны гэрээний хэрэгжилт хангалттай үнэлэгдэж, гэрээ үргэлжлүүлэн байгуулах эрүүл | Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээг нийт 74 эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулан албажуулж, нийт 1400 эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээнд | I - улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэндийн байгууллагуудтай байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна. | | | мэндийн байгууллагуудтай байгуулах. | нэгдсэн дугаар олгож бүртгэлийн санд бүртгэсэн. | | |
| 2 | Батлагдсан төсвийн хүрээнд гэрээт эрүүл мэндийн байгууллагуудтай хэлцэл хийж, хүний нөөцийн чадавхи, хүчин чадлыг харгалзан үзүүлэх тусламж үйлчилгээний тоо хэмжээг оношийн хамааралтай бүлэг бүрээр тохирч гэрээнд тусгана. | Нэмэлт гэрээ байгуулах гэрээний загварыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. | | Тухай бүр асуудлыг судлаж, шийдвэрлэх | ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудтай 2022 онд байгуулсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-нд нэмэлт гэрээний төслийг Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомж, ЭМДҮЗ-ийн тогтоолд нийцүүлэн боловсруулсан. | I - II улирал | 100% |
| 3 | Сонгон шалгаруулалт, гэрээлэлт, гэрээний хэрэгжилтийн асуудлаар шүүхийн хэрэг маргаанд төлөөллөөр оролцох, удирдлагыг мэдээллээр хангах, тайлагнах. | Байгууллагыг төлөөлөн зөрчлийн болон шүүхийн маргаанд оролцсон тоо | - | Удирдлагаар итгэмжлэгсэн төлөөлөгчөөр оруулцуулахаар томилсон тохиолдол тухай бүрт | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт холбогдох дор дурдсан захиргааны хэрэгт хариуцагч байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байна. Үүнд:<br><br>1.“Болормэлмий” ХХК-ийн нэхэмжлэлтэй 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 08/4369 дугаар захиргааны актыг хууль бус болохыг тогтоолгох, хууль бус шийдвэрийн улмаас учирсан хохирол буюу хасагдсан 85,232,000 төгрөгийг гаргуулах, 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 08/4068 дугаар захиргааны актыг хууль бус болохыг тогтоолгох, хууль бус шийдвэрийн | I - IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | улмаас учирсан хохирол буюу 2023 оны 09 дүгээр сарын төлбөрөөс хасагдсан 7,756,000 төгрөгийг гаргуулахыг хүссэн нэхэмжлэл.<br><br>Тухайн нэхэмжлэлд шүүх 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр захиргааны хэрэг үүсгэж хэргийг 2025 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр хянан хэлэлцэж нэхэмжлэгчээс гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг ханган шийдвэрлэсэн тул Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргахаар ажиллаж байна.<br><br>2. “Болормэлмий” ХХК-ийн нэхэмжлэлтэй 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 06/4336 дугаар захиргааны актыг хууль бус болохыг тогтоолгох, хууль бус шийдвэрийн улмаас олгогдоогүй 2023 оны 05, 06 дугаар саруудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөр болох 570,193,750 төгрөгийг гаргуулахыг хүссэн нэхэмжлэл.<br><br>Тухайн нэхэмжлэлд шүүх 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдөр захиргааны хэрэг үүсгэсэн бөгөөд 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хянан хэлэлцэж, нэхэмжлэгчээс гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг ханган шийдвэрлэсэн тул шийдвэрийг гардан авч Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргахаар ажиллаж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3. “Дүйчинравжаа” ХХК-ийн нэхэмжлэлтэй 2024 оны 12 дугаар сарын 26-ний өдрийн 02/4658 дугаар шийдвэрийг хууль бус болохыг тогтоолгох, хууль бус шийдвэрийн улмаас олгогдоогүй даатгуулагчдад хөнгөлөлтэй олгосон эмийн үнэ болох 7,376,036 төгрөгийг гаргуулахыг хүссэн нэхэмжлэл.<br><br>Хэргийг шүүх 2025 оны 04 дүгээр сарын 23-ны хянан хэлэлцэж хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзан шийдвэрлэсэн. Шийдвэрийг эс зөвшөөрч нэхэмжлэгч байгууллага Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан.<br><br>4. “Борталын хишиг” ХХК-ийн нэхэмжлэлтэй 2022-2024 оны хугацаанд бүрэн олгогдоогүй санхүүжилт болох 807,577,300 төгрөгийг гаргуулахыг хүссэн нэхэмжлэл.<br><br>Тухайн нэхэмжлэлд шүүх 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр захиргааны хэрэг үүсгэж, шүүх хурлыг 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдөр хийхээр товлосон.<br><br>5. “Монос Хэнтий” ХХК-ийн нэхэмжлэлтэй 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 05/994 дугаартай шийдвэр хууль бус болохыг тогтоолгож, 2022 оны 05 сард даатгуулагчдад хөнгөлөлтэй олгосон | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эмийн үнэ болох 6,174,275 төгрөг, 2022 оны 12 дугаар сарын эмийн хөнгөлөлтийн дутуу төлбөр болох 1,157,272 төгрөг нийт 7,331,547 төгрөгийг нөхөн гаргуулахыг хүссэн нэхэмжлэл.<br><br>Хэргийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 128/ШШ2024/0778 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн тул хариуцагч байгууллагын давж заалдах гомдлоор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хянан хэлэлцэж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгон, дахин хэлэлцүүлээр буцаасан.<br><br>Анхан шатны шүүхийн хурлыг 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр товлон зарласан.<br><br>6. “Монос Өвөрхангай” ХХК-ийн нэхэмжлэлтэй 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 05/1568 дугаартай шийдвэр хууль бус болохыг тогтоолгох, даатгуулагчдад хөнгөлөлтэй олгосон эмийн үнэ болох 4,280,094 төгрөгийг гаргуулахыг хүссэн нэхэмжлэл.<br><br>Хэргийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 128/ШШ2024/1007 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг хангаН шийдвэрлэсэн тул хариуцагч байгууллагын давж заалдах гомдлоор | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2025 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр хянан хэлэлцэж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгон дахин хэлэлцүүлэхээр буцаан шийдвэрлэсэн. | | |
| 4 | Хэрэг, маргаан шийдвэрлэх ажиллагааны журмыг чанд баримтлах бөгөөд өөрийн гаргаж буй санал, хүсэлт, баримт сэлт, гомдлыг хуульд заасан хэлбэр, журмын дагуу гаргаж, баталгаажуулах. | Хэрэг, маргааныг шийдвэрлэх байгууллагаас буцаагүй, шийдэвлэгдсэн байх. | Хуулийн байгууллагад гаргаж буй санал, хүсэлт, баримт сэлт, гомдлыг хуульд заасан хэлбэр, журмын дагуу гаргаж, баталгаажуулсан байна. | Шүүхээс нотлох баримт ирүүлэхийг шаардсан тухай бүрт | Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд заасан хэрэгт хамаарал бүхий нотлох баримтыг тухай бүр хуулийн хугацаанд гарган Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэгт заасан нотлох баримтын шаардлагыг хангуулан хүргүүлсэн. | I - II улирал | 100% |
| 5 | “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ” тус бүрийг хууль зүйн техник талаас нь хянах. | Гэрээний эрх зүйн үндэслэлийг хянасан гэрээний тоо. | - | Байгуулагдсан гэрээ тус бүрээр | Эрүүл мэндийн байгууллага, эмийн сантай байгуулах “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-ний нэмэлт гэрээний загварыг боловсруулах, Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний хууль зүйн үндэслэлийг хянасан. | I-II улирал | 100% |
| Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна. | | | | | | | |
| 1 | ГГТ-3.2.4 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль тогтоомж, ЭМДҮЗ-ийн тогтоолтой нийцүүлэн “Газар дээр нь очиж хийх хяналт шалгалтын журам”-ыг шинэчлэн батлана. | Шинэчлэн батлагдсан журам | ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/60 дугаар тушаал хэрэгжсэн байна. | Журмыг шинэчлэн боловсруулж батлан хэрэгжүүлсэн байна | Журмын төсөл боловсруулагдах шатандаа явж байна. | I - II улирал | 100% |
| Зорилго 4. Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана. | | | | | | | |
| Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжине. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ГГТ-4.1.5<br>Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийг дагаж мөрдөн, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулна. | -Хос бичгээр хөтлөн гаргасан албан бичгийн тоо,<br><br>-Хэрэгжилтийн хувь | | | Байгууллагын хэмжээнд төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах ажил хэрэгжиж эхлээгүй байна. | I - II улирал | 100% |
| 2 | ГГТ-4.1.6<br>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана. | Хэрэгжилтийн хувь | | Тус газарт хамаарах заалтын хэрэгжилтийг хангаж тайлагнасан байна. | | I - II улирал | 100% |
| 3 | ГГТ-4.1.9<br>Даатгуулагч-иргэн, гэрээт байгууллагуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг тодорхойлж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ . | -Судалгаанд хамрагдсан иргэн, байгууллагын тоо<br><br>-Үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | | -Сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг тооцон үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.<br><br>-Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулдаг судалгаатай уялдуулсан байна. | Даатгуулагч-иргэн, гэрээт байгууллагуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг дүнг нэгтгэн ажилласан. | I - II улирал | 100% |
| 4 | ГГТ-4.1.13<br>Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, албан бичгийг шуурхай шийдвэрлэнэ. | Шийдвэрлэлтийн хувь | -2024 онд 2329 албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн.<br><br>-"Иргэд олон нийттэй харилцах" 11-11 төвд нийт 144 өргөдөл, гомдлыг | Өргөдөл, гомдол, санал, хүсэлт, албан бичгийг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна | -"Иргэд олон нийттэй харилцах" 11-11 төвд нийт 4 өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэсэн.<br><br>-Иргэн-даатгуулагч, эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн 62 өргөдөлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Үүнд:<br><br>1. "Дархан-Оточ" ХХК-иас ирүүлсэн 2025 оны 03 сарын хяналтад | I - II улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүлээн авч, шийдвэрлэсэн.<br><br>-Хэрэглэгчтэй харилцах төвийн 1800-1363 лавлах утсанд ирсэн 515 өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэсэн. | | түүвэрлэгдсэн өвчний түүхийг 2025 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр илгээх байсан боловч сервер компьютерийн хард дискэд гэмтэл үүссэн шалтгаанаар хоцроож 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр илгээснийг хүлээн авч зохих журмын дагуу дагуу хяналтад авч шийдвэрлэж өгөхийг хүссэн өргөдлийг судлан хуульд заасан хүндэтгэн үзэх шалтгаан тогтоогдохгүй байна гэж үзсэн,<br><br>2. “Гоо ботууль” ХХК, “Их нахиа фарм” ХХК, “Гоо юлт фарм” ХХК, “Их Халзан Бүргэдэй” ХХК нь хүндэтгэн үзэх шалтгаанаар “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ”-ний 2.4.4-т заасан хугацаанд ирүүлээгүй нэхэмжлэлийг хянуулахыг хүссэн өргөдлийг нотлох баримт, хууль, эрх зүйн судлан хүндэтгэн үзэх шалтгаантай гэж үзэн нэхэмжлэлийг хянуулахаар шилжүүлсэн.<br><br>3. “Ивээхүй” ХХК, “Буянт асгат хайрхан” ХХК, “Франтра” ХХК нь хүндэтгэн үзэх шалтгаанаар “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ”-ний 2.4.4-т заасан хугацаанд ирүүлээгүй нэхэмжлэлийг хянуулахыг хүссэн өргөдлийг нотлох баримт, хууль, эрх зүйн судлан хүндэтгэн үзэх шалтгаангүй гэж үзсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн 3 гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэсэн. Үүнд:<br><br>1. “Монос Сүхбаатар” ХХК даатгуулагчдад хөнгөлттэй олгосон эмийн үнээс 2019, 2020 онуудад нийт 16,980,085 төгрөгийг хассаныг олгохыг хүссэн өргөдлийг судлан нэхэмжилсэн үнийн дүнгээс дутуу санхүүжүүлсэн нөхцөл байдал тогтоогдоогүй гэж үзэн хариу хүргүүлсэн.<br><br>2. “Монос Дундговь” ХХК-ийн 2022 оны 06 дугаар сарын 11-нээс 7 дугаар сарын 31-ны өдөр хүртэлх хугацааны даатгуулагчдад хөнгөлөлттэй олгосон эмийн үнэ 9,854,529 төгрөг гаргуулахыг хүссэн өргөдлийг судлан хариу хүргүүлэхэд бэлэн болсон.<br><br>Даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр:<br><br>1. “Алтан могой” эмийн сангийн 2023 оны 02-05 сарын даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлсэн гүйцэтгэлийн нэхэмжлэл нийт 6,950,901 төгрөгийг гаргуулахыг хүссэн гомдлыг нотлох баримт болон хууль, эрх зүйн талаас нь судлан хурлаар хэлэлцүүлэн олгохоор шийдвэрлэсэн. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх | Цаг хугацаанд нь биелүүлсэн байна. | | Цаг хугацаанд нь биелүүлсэн байна. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн гүйцэтгэсэн. | I - IV улирал | 100% |
| 2. | Хүндэтгэн үзэх шалтгааныг тогтоох | Хуульд нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргасан байна. | | Хүндэтгэн үзэх шалтгааныг тогтоосон байна. | Эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”, “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ”-нд заасан хүндэтгэн үзэх шалтгааныг нийт 7 эрүүл мэндийн даатгалын байгууллагаас ирүүлсэн хүсэлт, нотлох баримтыг судлан дүгнэлт гаргасан. | I - IV улирал | 100% |
| 3. | | | | | | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Газар, хэлтсийн хэмжээнд болон чиг үүргийн хүрээнд явагдах сургалт, семинарт оролцож, шинэчлэгдсэн хууль, тогтоомж, дүрэм, журам, заавартай танилцаж судлах. | Сургалт семинарт идэвхтэй оролцож мэдлэгээ дээшлүүлсэн байна. | 2-оос доошгүй сургалтад хамрагдсан байх | Сургалт, семинарт оролцож, шинэчлэгдсэн хууль, тогтоомж, дүрэм, журам, заавартай танилцаж судлах. | Шинэчлэгдсэн хууль, тогтоолтой танилцаж ажиллаж байна. | I - II улирал | 100% |
| 2 | Эрхэлсэн чиг үүргийн хүрээнд боловсрол, мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх, ур чадвараа сайжруулах чиглэлээр цаг үеийн сургалтад хамрагдах. | Байгууллагаас зохион байгуулагдаагүй | | Цаг үеийн сургалтад хамрагдах. | Долоо хоног бүрийн мэдээллийн цагт хамрагдаж байна. | I - II улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургалт, семинарт хамрагдах | | | | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ХУУЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ................................... / Д.УЯНГА / ......... ......... .........

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*